

1. China. Imperial Maritime customs. III.-Miscellaneous Series: No. 19, Treaties Regulations, etc., Between Corea and Other Powers, 1876-1889, Shanghai: 1891
2. Myung Hyun Cho, Korea and The Major Powers *An Analysis of Power Structures in East Asia: Korean Unification Studies* 7, Seoul., 1987
3. C.I.Eugene Kim, Han-Kyo Kim, Korea and the Politics of Imperialism 1876-1910, Berkeley and Los Angeles, 1967
4. Frederick Foo Chien, The Opening of Korea, A Study of Chinese Diplomacy, The Shoe String press, Inc. 1967
5. Woonsang Choi, The Diplomatic History of Korea, Seoul, 1987
6. Richard Saccome, Koreans to Remember: 50 Famous People Who Helped Shape Korea Seoul, 1993
7. Ku Dae Yeol, A Korean Diplomat in London: Yi Hanpung and Anglo-Korean Relations Vol. XV, No.3, Korea Observer, Vol.XV, No.3, pp, 361-380
8. Paul H. Clyde and Burton F. Veers, The Far East: A History of Western Impacts and Eastern Responses, 1830-1875. Prentice Hall, 1976 (Sixth Edition).
9. M.Federick Nelson, Korea and the Old Orders in Eastern Asia, New York, 1967
10. Han Woo-Keun, The History of Korea, Seoul, 1986. (Seventeenth Edition).
11. Pyung-Do Yi, Litt. D, The Impact of the West on 19th Century Korea, Korean Quarterly, Summer, 1959, Vol. 1, No.1
12. Choi Mun-Hyung, The Onslaught of Imperialist Powers and its Influence in Korea, Korea Journal, March., 1984.

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРСАМЖ

АЛТАН АРСАМЖ

VOL.3

1/2000

ТӨРД ЗҮТГЭСЭН ТҮҮХТ ЭМЭГТЭЙЧҮҮД
ТҮМЭДИЙН АЛТАН ХАНЫ ИХ ЮНГЭН ХАТАНМУИС, НУФ, Түүхийн тэнхимийн багш түүхийн
уханы дэд доктор Ж.Урангуя

1368 онд Монголын эзэнт гүрэн-Юан улс мөхсөний дараа Монгол оронд Чингис, Тулуй, Тогоонтөмөр нарын угсааны хаадын төр барьсан Монгол улс оршин тогтнож байсан юм. Энэ үеийн Монгол орныг түүхэнд Умард Юань улс гэж нэрлэдэг. Умард Юань улсын ноёрхогчид нэг талаар Монголын олон аймгаа нэгтгэн захирч, нөгөө талаар Хятадад ноёрхлоо сэргээхийн тул шинэ мандсан Хятадын Мин улсын эсрэг удаа дараалан довтолж байсан боловч амжилт төдийлөн олохгүй байв.

1558-1895 онуудад Монголын хаан ширээнд Түмэн хаан заларч байв. Монгол улсын нэгдмэл байдлыг бэхжүүлэх талаар Түмэн хаан нилээд зүйлийг хийсэн. Тэрээр Зүүн, Баруун түмний ноён, сайдаар бүрэлдсэн төв засгийн газар байгуулсан учир "засагт" хаан хэмээн алдаршжээ.

Энэ үед Халхад Абтай хан, Түмэдэд Алтан хан, ордост Хутагтай сэцэн хунтайж нарын зэрэг ихээхэн нэр нөлөө бүхий төр, цэргийн болон соёлын томоохон зүтгэлтэн нар үйл ажиллагаа явуулж байсан. Түмэн засагт хаан тэдэнтэй хамт төрийн бодлого боловсруулж, тэдний үйл ажиллагааг чиглүүлэн зохицуулж хөтөлдөг байлаа.

Түмэдийн Алтан хан Хятадтай хаая даран зэрэгцэж оршдогийн хувьд Мин улстай худалдаа-эдийн засаг, улс төрийн найрсаг харилцаа тогтоож сайн хөршийн ёсоор харилцахыг арга буюу эрхэмлэж байсан боловч Мин улсын буруугаас болж Алтан хан арга буюу түүний эсрэг олон удаа довтолгоо дайралт хийж,

Мин улсын нийслэл Бээжин хотод хүртэл тулж очиж байжээ. Алтан хан 1541 оны намар Шаньси мужийн Датун хотод адууны зах нээж, худалдаа хийхийг хүсэж Мин улсын хаанд элч явуулсан боловч түүнийг зөвшөөрсөнгүйгээр үл барам, харин ч Алтан ханы толгойг Бээжинд авчирсан хүнд шагнал өгнө гэж зарлаж байжээ. Энэ нь Алтан ханы дургүйцлийг ихэд хүргэж, Алтан ханыг Мин улсын хил хязгаарыг уулгалан дайрахад хүргэжээ. 1542 оны зун Алтан хан дахин элч зарж Датунд адууны зах нээж худалдаа хийхийг хүссэнд Мин улс энэ удаа Алтан ханы явуулсан элчийг нь алжээ. Үүнээс болж Алтан хан Мин Улсын Ляодун, Шаньси, Шэньси зэрэг муж газрыг дайчээ.

Түмэдийн Алтан хан олон жилийн турш Мин улсыг дайран довтолж гол шалтгаан нь эдийн засгийн үндэстэй байсныг Мин улсын Шаньси мужийн ерөнхий захирагч Ван Чунгуу үзэж, тэрээр хаандаа олон удаа зөвлөж айлгахдаа: "...нүүдэлчид суурьшсан ард иргэдийн тариа будаа, бөс даавуу, ахуй амьдралд зайлшгүй шаардагдах өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үргэлж шаардлагатай байдаг учир, тэдний энэхүү шаардлагыг хангаагүй нөхцөлд манай улсыг уулгалан дайрах явдал нь зогсохгүй учир Алтан ханы хүссэн ёсоор худалдаа арилжаа хийхийг зөвшөөрөх хэрэгтэй" гэжээ. Алтан ханы Мин улсыг довтолжон дайрах явдал 1570 он хүртэл үргэлжилжээ. Энэ хугацаанд зөвхөн Алтан хан бус, Түмэн засагт хаан ч мөн Мин улсыг хэд хэдэн удаа довтолжон дайрчээ.

Ван Чунгуу тэргүүтэй зарим түшмэд Алтан ханы найрамдан, худалдаа хийх саналыг хүлээн авах хэрэгтэй хэмээн хаандаа хүчлэн сануулсныг Мин улсын Му-Зун хаан ёсоор болгож Алтан хантай найрамдлын харилцаа тогтоохоор шийджээ.

1570 онд Мин улсын Му-Зун хаан Алтан ханд "журмыг дагагч" ван хэмээх цол өргөмжлөн, их хэмжээний бэлэг шан өгчээ. 1571 онд Алтан хан хариуд нь 509 морь бэлэглэн цаашид айл хөршийн эв найрамдалтай байх ба харилцан арилжаа худалдаа хийх тухай саналдаа илэрхийлсэн бичгийг Мин улсын хаанд илгээжээ. Мөн онд Мин улс Алтан ханы саналыг хүлээн авч Датун, Чуулалт хаалга зэрэг хил орчмын газар нутагт адууны зах нээсэн юм.

Монголын баруун гар Түмэдийн түрүү Алтан ханы эхнэр Юнгэн хатан /1550-1612/ бол ухаалаг, үзэсгэлэн гоо, авьяас билэгтэй бүсгүй ажээ. Энэ үеэр Алтан хан нэгэнт нас өндөр болсон байсан

тул, түүний хатан Юнгэн төрийн хэрэгт оролцож найдвартай түшиг тулгуур зөвлөгч нь болж байлаа. Залуу насны Юнгэн хатан өнгө зүс гоо үзэсгэлэн мөртөө бас хурц сэрэлэн ухаан санаатай хүн байв. Тэр жилд нэг удаа явагдах Монгол Хятадын харилцан алба барих ба арилжаа худалдаа хийх ажлыг өөрийн биеэрээ эрхэлж явуулдаг байсан учраас говийн өмнөх Монголын аймгийн дунд ихээхэн нэр хүндтэй болсон юм. Юнгэн хатан үргэлж нэхий дээл өмсөж, бултаны арьсан малгай өмсөж, морь унаж саадаг агсан, хил хязгаар орноор байцааж явах ба Монгол Хятадын найрамдлын хэлэлцээрт тогтоосон зүйлс хэрхэн явагдаж байгааг хянан ингэснээрээ хязгаар нутаг амар тайван, ард иргэд амар жимэр аж төрөн, аюул зовлонд унахгүй болно гэж үзэж байжээ.

1581 оны 12-р сарын 19-нд Алтан хан 75 насан дээрээ өвчнөөр нас баржээ. Түүний орыг ахмад хөвгүүн Дүүрэн Сэнгэ хунтайж / Алтан ханы өөр хатнаас төрсөн хөвүүн / залгамжилсан. Дүүрэн Сэнгэ хунтайж Юнгэн хатныг хатнаа болооч хэмээн гуйжээ. Энэ үед Юнгэн хатан сая гуч гарч явсан бөгөөд бусдын дургаар явах дорой эмэгтэй биш байсан тул нас /өндөр болсон/ ахисан Дүүрэн Сэнгэ Хунтайжтай суух дургүй байсан тул олон харьяат аймгаа авч одоогийн Хөх хотоос салж явсан юм.

Дүүрэн Сэнгэ хунтайж Юнгэн хатнаа болгон ураглах гэсэн нь учиртай юм. Тэр хэдийгээр Алтан ханы суурийг залгамжилсан боловч, Юнгэн хатны дэмжлэг тусламжийг олохгүй бол, аймаг угсааны дотоодод их зөрчил тэмцэл гарах бололцоотой гэдгийг тод тодорхой мэдэж байлаа. Энэ үед Мин улсаас ноёд түшмэд томилон ирүүлж Юнгэн хатныг ятган сануулж, Монгол Хятадын харилцааг бодолхийлж хунтайжийн хатан болвол, Мин улс сая түүний байр суурийг дэмжинэ гэдгээ илэрхийлж байжээ. Ухаалаг, сэрэн Юнгэн энэ нөхцөл байдлыг тунгаан бодож Дүүрэн Сэнгэ хунтайжийн эхнэр болжээ.

1587 онд Дүүрэн Сэнгэ хунтайж 65 насандаа нас барсны дараа, дотоодын хямралдаан үүсч, хагацал задрал үүсэх болсонд Юнгэн хатан Дүүрэн Сэнгэ хунтайжийн орыг залгамжилсан Амудай Сэцэн хунтайжийг хавсарч, төрийн явдлыг шийдвэртлэж байсан бөгөөд Монгол Хятад энэ үедээ эв найрамдалтай оршин суухад зүтгэн чармайж явав.

Мин улс Юнгэн хатны нөхөрсөг сэтгэлгээг харуулахын тулд

түүнийг "Үнэнч шударга хатан"-аар өргөмжилсөн байдаг.

Тэрээр 1612 онд жаран гурван насан дээрээ нас баржээ. Монголд ч мөн Хятад оронд ч түүнийг дурсан мөрөөдөж маш олон бичгийн мэргэд түүнийг шүлэглэн магтаад, уран зураачид түүний хөрөг зургийг зурж бүтээсэн байдаг. Түүний алдар гавьяаг дурсахын төлөө түүхэнд түүний амьдарч байсан Хөх хотыг нэгэн үе "Юнгэн хатан хот" гэж дуудаж байжээ.

Юнгэн хатан Монгол оронд шарын шашин дэлгэрүүлэхэд хүч гарган зүтгэсэн байна. Алтан хан шарын шашныг Түвдээс оруулан авчрахад Юнгэн хатан их үйлдэл үзүүлсэн тухай сурвалж бичигт тэмдэглэгдсэн байдаг. Шарын шашин Монгол оронд дэлгэрсний дараа тэр бас олон чухал ажил хийжээ. Тухайлбал 1586 онд Далай лам Юнгэн хатанд зарлиг буулгаж "Балбын орон /одоогийн Непал/-аар алтан титэм хийлгэж, дээд зуу Шигэмүни /Шаржамуни/ бурханд өмсөөд ... хутаг оршуулсан" гэсэн тэмдэглэл Монголын судар бичгүүдэд байдаг.

Юнгэн хатан Амуудай Сэцэн хан, Бодашир хунтайж нартай хамтран, ширээт гүүш цорж Аюуш, Ананда Манчир болон баруун гурван түмний хэлмэрч мэргэдийг зохион байгуулж, 1602-1607 он хүртэл зургаан жилийн хугацаанд "Ганжуур"-ыг монгол хэлнээ орчуулсан ажээ. Үүнээс үзэхэд Юнгэн хатан бол Монголын соёлын хөгжилтөнд гавьяа зүтгэл гаргасан хүн юм.

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРГАМЖ

АЛТАН АРГАМЖ

VOL.3

1/2000

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН АЮУЛГҮЙ

БАЙДАЛ,

ЦӨМИЙН ЗЭВСЭГТҮЙ СТАТУС

Т.Арунсанаа

ОУХС-ийн магистрант

Өнгөрсөн найман жилийн гол үйл явдлууд, ололтуудыг жагсаан үзвээс хэдэн гол үр дүнд хүрсэн нь, мөн хэдэн зөрчилтэй асуудал оршин буй нь илэрч байна. Гол ололтууд гэвэл: Цөмийн зэвсэгтэй улсууд Монголттой холбогдуулан мэдэгдэл гаргасан; НҮБ-ын ЕА-аас 53/77D тогтоол батлуулсан; Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль баталсан явдал байна. Зөрчилтэй асуудлууд нэлээн хэд байгаагаас хамгийн гол нь үндэсний аюулгүй байдал хангагдаж буй эсэх тухай асуудал байна.

Цөмийн зэвсэгтэй улсууд аюулгүйн

баталгаа гаргасан байдал

Монгол улс өөрийн газар нутгаа цөмийн зэвсэгтэй бүс болгох тухай бодлогоо тунхагласны дараа цөмийн зэвсэгтэй гурнууд Монгол улстай холбогдуулан тус бүртээ мэдэгдэл хийсэн юм. Энэ талаар зарим сонин хэвлэлд Монгол улсын аюулгүй байдал хангагдаж буй мэтээр дурдсан байдаг. Тэгвэл бодит байдал дээр эдгээр баталгаа нь Монгол улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалд дурдсан "Монгол улсын үндэсний ялгуур ашиг сонирхлыг хангах гадаад дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан" тухай шалгуурт нийцэж байгаа эсэх нь эргэлзээтэй